



IV/1

**ТӨРИЙН ӨМЧИЙН БОДЛОГО,
ЗОХИЦУУЛАЛТЫН ГАЗРЫН ДАРГЫН
ТУШААЛ**

2024 оны 4 сарын 1 өдөр

Дугаар А/19

Улаанбаатар хот

Ажлын хэсэг байгуулах тухай

Засгийн газрын агентлагийн эрх зүйн байдлын тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.4 дэх хэсэг, Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хуулийн 11 дүгээр зүйлийн 3 дахь хэсэг, "Төрийн өмчит хуулийн этгээдийн захиралтай онцгой нөхцөл бүхий хөдөлмөрийн гэрээ байгуулах, дүгнэх журам"-ын 3.1 дэх хэсгийг тус тус үндэслэн ТУШААХ нь:

1. Төрийн өмчит компанийн гүйцэтгэх захирал, төрийн өмчит үйлдвэрийн газрын захиралтай байгуулсан Онцгой нөхцөл бүхий хөдөлмөрийн гэрээ, 2023 оны эдийн засгийн үндсэн үзүүлэлт, зорилтот түвшин, хөрөнгө оруулалтын төлөвлөгөөний биелэлтийг хэлэлцэн санал дүгнэлт боловсруулах үүрэг бүхий ажлын хэсгийг дараах бүрэлдэхүүнтэй байгуулсугай.

Ахлагч:

Ц.Баяр-Эрдэнэ

Төрийн өмчийн удирдлага, зохицуулалтын хэлтсийн дарга

Дэд ахлагч:

В.Дарханбаатар

Төрийн өмчийн удирдлага, зохицуулалтын хэлтсийн Удирдлага, төлөөллийн албаны дарга

Гишүүд:

Ц.Шинэхүү

Төрийн өмчийн удирдлага, зохицуулалтын хэлтсийн Төлөвлөлт, хөрөнгө оруулалтын албаны дарга

Х.Энхчимэг

Захиргаа, удирдлагын хэлтсийн ахлах мэргэжилтэн

Д.Сувдмаа

Төрийн өмчийн хяналт, шалгалтын хэлтсийн ахлах мэргэжилтэн

Б.Мөнхбаатар

Төрийн өмчийн бүртгэл, ашиглалтын хэлтсийн ахлах мэргэжилтэн

Ө.Саранцэцэг

Хууль, эрх зүйн хэлтсийн ахлах мэргэжилтэн

Г.Дэлгэрмаа

Төрийн өмчийн удирдлага, зохицуулалтын хэлтсийн мэргэжилтэн

Д.Одмаа

Төрийн өмчийн удирдлага, зохицуулалтын хэлтсийн мэргэжилтэн

Д.Дариймаа

Төрийн өмчийн удирдлага, зохицуулалтын хэлтсийн мэргэжилтэн

Б.Амарбаясгалан

Төрийн өмчийн удирдлага, зохицуулалтын хэлтсийн мэргэжилтэн

Г.Нямдаваа

Төрийн өмчийн удирдлага, зохицуулалтын хэлтсийн мэргэжилтэн


132013909

Б.Билгүтэ	Төрийн өмчийн удирдлага, зохицуулалтын хэлтсийн мэргэжилтэн
Нарийн бичиг: А.Молор	Төрийн өмчийн удирдлага, зохицуулалтын хэлтсийн мэргэжилтэн
О.Ишханд	Төрийн өмчийн удирдлага, зохицуулалтын хэлтсийн мэргэжилтэн

2. Ажлын хэсгийн ажиллах удирдамжийг хавсралтаар баталсугай.

3.Төрийн өмчит компанийн гүйцэтгэх захирал, үйлдвэрийн газрын захиралтай байгуулсан Онцгой нөхцөл бүхий хөдөлмөрийн гэрээ, 2023 оны эдийн засгийн үндсэн үзүүлэлт, зорилтот түвшин, хөрөнгө оруулалтын төлөвлөгөөний биелэлтийг хэлэлцэн 2024 оны 04 дүгээр сард багтаан санал дүгнэлт боловсруулан Төрийн өмчийн бодлого, зохицуулалтын газрын хуралд танилцуулан шийдвэрлүүлэхийг Ажлын хэсэг (Ц.Баяр-Эрдэнэ)-т үүрэг болгосугай.

ДАРГА



Б.ЦЭНГЭЛ

Төрийн өмчийн бодлого, зохицуулалтын газрын
даргын 2024 оны 04 дүгээр сарын 01-ний өдрийн А.19
дугаар тушаалын хавсралт

АЖЛЫН ХЭСГИЙН АЖИЛЛАХ УДИРДАМЖ

Нэг: Зорилго

Ажлын хэсэг нь “Төрийн өмчит хуулийн этгээдийн захиралтай онцгой нөхцөл бүхий хөдөлмөрийн гэрээ байгуулах, дүгнэх журам”-д заасны дагуу 2023 оны жилийн эцсийн Аудитаар баталгаажсан санхүүгийн тайлан, дүгнэлт, салбарын яам болон төрийн захиргааны байгууллагын дүгнэлт, Төлөөлөн удирдах зөвлөлийн шийдвэр, дүгнэлтийг авсны үндсэн дээр Төрийн өмчит компанийн гүйцэтгэх захирал, төрийн өмчит үйлдвэрийн газрын захиралтай байгуулсан Онцгой нөхцөл бүхий хөдөлмөрийн гэрээ, 2023 оны эдийн засгийн үндсэн үзүүлэлт, зорилтот түвшин, хөрөнгө оруулалтын төлөвлөгөөний биелэлтийг хэлэлцэн санал дүгнэлт боловсруулахдаа энэхүү удирдамжийг баримтална.

Хоёр: Хийгдэх ажлын чиглэл

1. Төрийн өмчит компанийн гүйцэтгэх захирал, төрийн өмчит үйлдвэрийн газрын захиралуудын Онцгой нөхцөл бүхий хөдөлмөрийн гэрээ, 2023 оны эдийн засгийн үндсэн үзүүлэлт, зорилтот түвшин, хөрөнгө оруулалтын төлөвлөгөөний биелэлтийг шалгуур үзүүлэлтийн дагуу үнэлж, дүгнэлт өгөх;

2. “Төрийн өмчит хуулийн этгээдийн захиралтай онцгой нөхцөл бүхий хөдөлмөрийн гэрээ байгуулах, дүгнэх журам”-ын 3.2, 3.3-т заасан материалыг судалж, санал дүгнэлт боловсруулан Төрийн өмчийн бодлого, зохицуулалтын газрын хуралдаанаар хэлэлцүүлэх бэлтгэл хангана;

3. Гэрээний биелэлтийн шалгуур үзүүлэлтээр “Сайн” гэж дүгнэгдсэн хуулийн этгээдийн захиралд урамшуулал олгох эсэх, “Хангалтгүй” гэж дүгнэгдсэн захиралд холбогдох хууль тогтоомж, тус гэрээнд заасан хариуцлага тооцох эсэх талаар санал, дүгнэлт гаргах;

4. Төрийн өмчит компани, төрийн өмчит үйлдвэрийн газруудын үйл ажиллагааг сайжруулах, цаашид авч хэрэгжүүлэх арга хэмжээний талаар санал дүгнэлт гаргах;

5. Ажлын хэсэг хуулийн этгээд болгон дээр санал, дүгнэлт гарган ажлын хэсгийн гишүүд гарын үсэг зурж баталгаажуулах бөгөөд Төрийн өмчийн бодлого, зохицуулалтын газрын хуралдаанд танилцуулан шийдвэрлүүлэх ажлыг зохион байгуулна.

Гурав: Үр дүн, хугацаа

Төрийн өмчит компанийн гүйцэтгэх захирал, төрийн өмчит үйлдвэрийн газрын захиралуудын Онцгой нөхцөл бүхий хөдөлмөрийн гэрээ, 2023 оны эдийн засгийн үндсэн үзүүлэлт, зорилтот түвшин, хөрөнгө оруулалтын төлөвлөгөөний биелэлтэд үнэлэлт, дүгнэлт өгч цаашид Гүйцэтгэх захирал, захирлуудтай Онцгой нөхцөл бүхий хөдөлмөрийн гэрээ байгуулах, гэрээг цуцлах талаарх санал дүгнэлтээ 2024 оны 04 дүгээр сард багтаан Төрийн өмчийн бодлого, зохицуулалтын газрын хуралд танилцуулан шийдвэрлүүлэх.

.....000.....